



**ХЭНТИЙ АЙМГИЙН
НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 30 өдөр

Дугаар A/102

Жаргалант

Бог малын мялзан өвчнөөс урьдчилан
сэргийлэх дархлаажуулалтын ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.2, 5.1.3, 5.1.4, 5.1.5 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, 6.5, 6.6 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, 9.4, 9.5, 9.6, 9.7 дахь хэсэг, 9.8.1, 9.8.2 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсэг, Малчны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.5 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, Хэнтий аймгийн засаг даргын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/436 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад сумын хэмжээний нийт бог малыг бүрэн хамруулах ажлыг 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн 08 дугаар сарын 22-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын удирдамж, стандарт ажиллагааны зааврын хүрээнд уг ажлыг шуурхай зохион байгуулах, дархлаажуулалтад шаардлагатай вакцин, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангах, дархлаажуулалтын явц, технологи, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч (О.Банхар)-т, урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтын мэдээ тайлан, үр дүнг танилцуулж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч (Э.Батдаваа)-д нарт үүрэг болгосугай.


3. Графикт хугацаанд малыг бүрэн дархлаажуулахыг Тахир нуур ХХК-ний малын эмч С.Сугаррагчаа, Эм Тун ХХК-ний захирал, малын эмч Э.Батцэцэг, Бодь-Тара ХХК-ний малын эмч Г.Гомбосүрэн нарт үүрэг болгосугай.

4. Малчдад урьдчилан мэдэгдэж тарилгын хашаа, хоолойг бэлдүүлэн, зарлан мэдээлэл хүргэж, хяналт тавьж ажиллахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад графикт хугацаанд мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн малчид, мал бүхий иргэд, заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бүрдүүлсэн албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч (О.Банхар)-т үүрэг болгосугай.

6. Төлөвлөгөөт ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (Д.Шижирмөнх)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.ДАВААЖАРГАЛ

D:bichig hereg /zahiramj-2025

232501239



Сумын Засаг даргын 2025 оны 17 дугаар сарын 30-ний өдрийн А/102 дугаар захирамжийн хавсралт

БОГ МАЛЫН МЯЛЗАН ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛӨХ ДАРХЛААЖУУЛАЛТАД ХАМРАГДАХ МАЛЫН ТОО,
ВАКЦИНЫ ХУВААРЬ

№	Сумын нэр	МЭҮН	Дархлаажуулах малын тоо					Шаардлагатай вакцин	
			Хонь	Ямаа	Хурга	Ишиг	Нийт	Шингэлэгч (мл)	Вакцин (тун)
1	Норовлин	Эм Тун	44535	32533	23067	21065	121200	121200	121200
		Бодь-Тара	22600	10000	10000	6800	49400	49400	49400
		Тахир нуур	38000	22200	18000	11400	89600	89600	89600
		Нийт	105135	64733	51067	39265	260200	260200	260200

Handwritten notes in red ink, possibly a list or index, located in the upper right quadrant of the page.

Борисовы
Хорошо
Хорошо 2
Очень